

ӨНДӨРХААН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 04 сарын 25-ны өдөр

Дугаар №1

Улаанбаатар хот

Өндөрхаан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11:00 цагаас <https://live.ard.mn/> сайтаар дамжуулан хурал эхлэв.

Хурлын дарга Г.Цогбадрах: Хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр Өндөрхаан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байна. Энэхүү хуралд Өндөрхаан ХК-ийн ТУЗ-ийн гишүүд болох Г.Цогбадрах, Б.Оюутцэцэн, Т.Билэгсайхан, мөн Өндөрхаан ХК-ийн гүйцэтгэх захирал О.Амарболд, хурал зохион байгуулах комиссын дарга Ц.Анударь, тооллогын комиссын дарга Г.Энхтуяа болон Өндөрхаан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл оролцохоор ирсэн байна. Хурлын дэгийг хурал зохион байгуулах комиссын дарга Ц.Анударь танилцуулна уу.

Хурал зохион байгуулах комиссын дарга Ц.Анударь: Уг хурлаар компанийн 2021 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах, компанийн бүртгэлтэй үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагыг өөрчлөх тухай болон бусад асуудлыг хэлэлцэх болно. Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт байвал та бүхэн асуулт, хариулт хэсэгт бичиж илгээнэ үү. Мөн хувьцаа эзэмшигчдийн зүгээс хэлэлцэх асуудалд асуулт санал байна уу?

Хэрэв хуралд оролцогчид болон хувьцаа эзэмшигчдээс маань асуулт байхгүй бол хурлаа эхэлцгээе.

Хурлын дарга Г.Цогбадрах: Хурлын ирцийг тооллогын комиссын дарга танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Г.Энхтуяа: Хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэнд хүргэе. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дахь заалт, 68 дугаар зүйлийн 68.4 дэх хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн тогтооход компанийн зарласан 111,879 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчдийн 91,288 ширхэг буюу 81.6 нь хуралд оролцсоноор өнөөдрийн хувьцаа эзэмшигчийн хурал хүчин төгөлдөр болж байна.

Хурлын дарга Г.Цогбадрах: За ойлголоо. Гүйцэтгэх захирал О.Амарболд компанийн танилцуулгыг тавина уу.

Гүйцэтгэх захирал О.Амарболд: Компанийн нэр, хаягийг өөрчлөх хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн. Нэр хаягийг өөрчилсний дараа урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг зохицуулагч байгууллагад хүргүүлнэ.

Өндөрхаан ХК-ын 2021 оны жилийн эцсээрх нийт актив 107,480 мянган төгрөг байна. Үүнд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 500 мянга дансны авлага 2,976 мянга урьдчилж төлсөн төлбөрт 100 сая төгрөг байгаа нь Ард секюритиз ҮЦК ХХК болон Өндөрхаан ХК-ийн хооронд байгуулсан андеррайтингийн үйлчилгээ үзүүлэх гэрээний төлбөр билээ. Орлогын дэлгэрэнгүй тайланг танилцуулвал 2021 оны жилийн эцсээр нийт 29,824 мянган төгрөгийн алдагдалтай байна. Хувь нийлүүлэх хөрөнгийг нэмэгдүүлэх ажилтай холбоотойгоор 2021 оны 11 сарын 30-ны өдрөөр тасалбар болгон Грант Торнтон аудит ХХК хөндлөнгийн аудит орсон бөгөөд зөвлөмжийн дагуу өмнөх тайлант хугацааны тодорхойлох боломжгүй 34,330 төгрөгийн дансны авлагыг данснаас хассан. Мөн өмнөх тайлант хугацаанд үүссэн нотлох боломжгүй 35,285 мянган төгрөгийн эздийн өмчийн бусад хэсгийг тайлант хугацааны бусад орлогоор хүлээн зөвшөөрч данснаас хассан. "Ворлд Фрейндс" ХХК-тай холбоотой 2,667

мянган төгрөгийн өглөгийг нэхэмжлэхгүй болохоо мэдэгдсэн тул бусад орлогоор хүлээн зөвшөөрч залруулсан. Бид үйл ажиллагааны зардалд 32,945 мянган төгрөг зарцуулсан байна.

Өндөрхаан ХК нь 2021 онд үйл ажиллагаа явуулаагүй тул 2022 оны 2 дугаар сарын 15 -ны өдрийн төлөөлөн удирдах зөвлөлийн 22/23 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэр гаргасан болно.

2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар Өндөрхаан ХК-ийн нийт 111,879 хувьцааг 309 хүн, хуулийн этгээд эзэмшиж байна.

Хурлын дарга Г.Цогбадрах: Компанийн танилцуулга хийсэн Гүйцэтгэх захиралд баярлалаа. Үргэлжлүүлэн хэлэлцэх асуудлуудыг ярилцах нь зүйтэй болов уу.

Хэлэлцэх асуудал №1. Компанийн 2021 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Компани нь 2017 оноос үйл ажиллагаа явуулаагүй талаар Гүйцэтгэх захирал О.Амарболд танилцуулгадаа дурдсан. 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчилсөн. Цаашид үйл ажиллагаа сэргэнэ гэдэгт итгэлтэй байна.

Хэлэлцсэн нь: Нэмэлт санал байхгүй.

Хэлэлцэх асуудал №2. Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай шийдвэрийн үндэслэлийг ТУЗ-өөс танилцуулах

Компани нь 2017 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй тул Ногдол ашиг хуваарилахгүй байх тогтоолыг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр гаргасан.

Хэлэлцсэн нь: Нэмэлт санал байхгүй.

Хэлэлцэх асуудал №3. Компанийн бүртгэлтэй үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагыг өөрчлөх тухай;

Гүйцэтгэх захирал О.Амарболд: Өндөрхаан ХК нь 1996 онд Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д үнэт цаасаа бүртгүүлсэн бөгөөд цаашид Улаанбаатар үнэт цаасны бирж ХК-ийн бүртгэлд шилжих нь бидэнд илүү давуу тал үүсгэх боломжтой байна. Мөн Улаанбаатар үнэт цаасны бирж ХК-ийн 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 94/22 тоот албан бичгээр "Өндөрхаан" ХК нь бүртгэлийн шалгуурыг ханган ажиллах баталгаа гаргасан тохиолдолд "Хөгжлийн талбар"-т бүртгэгдэх боломжтой хэмээн бидэнд мэдэгдсэн.

Хэлэлцсэн нь: Нэмэлт санал байхгүй.

Хурлын дарга Г.Цогбадрах: Хувьцаа эзэмшигч Г.Ашхүүгээс Монголын хөрөнгийн бирж ТӨХК-с Улаанбаатар үнэт цаасны бирж ХК-руу шилжиж буйг боломж гэж харж байна уу гэсэн асуулт ирсэн байна. Гүйцэтгэх захирал О.Амарболд хариулна уу.

Гүйцэтгэх захирал О.Амарболд: Улаанбаатар үнэт цаасны бирж ХК-ийн арилжааны хуваарь нь Монголын хөрөнгийн бирж ТӨХК-с илүү байдаг нь арилжааны идэвхэд нөлөөлөх болов уу. Мөн дэвшилтэт технологийг нэвтрүүлж буй нь бидэнд давуу тал үүсгэнэ гэж харж байна. Улаанбаатар үнэт цаасны бирж ХК-ийн арилжааны цаг урт, бүтээгдэхүүний сонголт, шинэлэг платформ, маржин арилжаа болон хөрвөх чадвар зэргээрээ гол давуу талыг үүсгэнэ гэж үзэж байна.

Хурлын дарга Г.Цогбадрах: Гүйцэтгэх захирал О.Амарболдод баярлалаа. Хувьцаа эзэмшигчдээс өөр асуулт ирүүлээгүй байна. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа. Хэлэлцсэн асуудлууд дээр та бүхэн 11:30 цагаас 11:50 цаг хүртэл саналаа <https://live.ard.mn/>- зэр санал хураалт хэсгээр дамжуулан өгнө үү.

Хурлын дарга Г.Цогбадрах: Өндөрхаан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай болж байна. Санал хураалтын дүнг тооллогын комиссын дарга Г.Энхтуяа танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Г.Энхтуяа: Хэлэлцэх асуудал бүрээр тооллогын дүнг та бүхэнд танилцуулъя.

Хэлэлцэх асуудал №1. Компанийн 2021 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай санал хураалтад саналын эрх бүхий 91,288 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

- 1.1. Зөвшөөрсөн – 91,288 ширхэг буюу 100%;
- 1.2. Татгалзсан 0 ширхэг 0%
- 1.3. Түдгэлзсэн 0 ширхэг 0% тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр хүчинтэй.

Хэлэлцэх асуудал №2. Компанийн бүртгэлтэй үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагыг өөрчлөх тухай санал хураалтад саналын эрх бүхий 55,488 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

- 2.1. Зөвшөөрсөн 55,488 ширхэг буюу 100%
- 2.2. Татгалзсан 0 ширхэг 0%
- 2.3. Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хоёрдугаар хэлэлцэх асуудлын санал хураалтад "Өндөрхаан" ХК-ийн 35,800 ширхэг энгийн хувьцааг эзэмшигч Г.Ашхүү нь тус асуудлаар сонирхлын зөрчилтэй буюу Улаанбаатар Үнэт цаасны бирж ХК-ийн ТУЗ-ийн гишүүн тул саналын эрхгүй байсан болно.

Хурлын дарга Г.Цогбадрах: Тооллогын комиссын дарга Г.Энхтуяад баярлалаа. Өндөрхаан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай өндөрлөж, хувьцаа

эзэмшигчдийн саналыг авч, нийт хоёр асуудлын хүрээнд хэлэлцэж шийдвэрлэв. Хуралдаа идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигчид та бүхэнд баярлалаа. Ингээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хаасныг мэдэгдэж байна.

Хурал 11 цаг 57 минутад дуусав.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ХУРЛЫН ДАРГА

Хурлын тэмдэглэлийг хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Г.ЦОГБАДРАХ

Ц.АНУДАРЬ